

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 03 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Амьтны тухай хуулиар чоно агнахад заавал хураамж төлж зөвшөөрөл авах ёстой гэж хуульчилсан нь өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдлийн соёлтой амьдарч байгаа малчин иргэдийн бодит амьдралд нийцэхгүй байгаа, гэнэтийн үед буюу амь нас, мал сүргээ хамгаалах шаардлага үүссэн тохиолдолд зөвшөөрөл авалгүй чоно агнавал малчин, иргэд торгууль, төлбөр төлөх, Монгол Улсын Үндсэн хуульд заасан амьд явах, өмчтэй байх эрх нь зөрчигдөж байна гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар чоно болон бусад зэрлэг амьтанд бариулж хүний амь нас хохирсон, гэмтсэн талаарх судалгаа, статистик байгаа эсэх, мал сүрэг нь хохирсон тохиолдолд нөхөн төлбөр авах боломж, хохирлыг хэрхэн барагдуулдаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төслийн талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагын баримталж байгаа бодлогын талаар, уг хуулийн төслийг дагаж Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орох эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал өргөн мэдүүлсэн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, хэлэлцүүлгийн шатанд хууль хоорондын нийцэл, уялдааг хангах, агнуур зүй, зохион байгуулалтын тоон мэдээллийг улс, бүс нутгийн хэмжээнд гаргаж, тусгай зөвшөөрлөөр агнах амьтдын тоо толгойг зохистой түвшинд байлгах асуудалд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын баримталж байгаа бодлого, чиглэлийн талаар тодрууллаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир тураг, хар галуу, тарвага, янгирийн зэрэг бусад амьтдыг нутагшуулах, too толгойг зохистой түвшинд байлгах асуудалд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны баримталж байгаа бодлогын талаар, малчид, иргэдэд зэрлэг амьтдаас амь нас, мал сүргээ хамгаалах талаар холбогдох мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулдаг эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат чоно болон ирвэсийн too толгой нэмэгдсэн эсэх, байгалийн тэнцвэрт байдал хангагдах зохистой түвшний талаар, чоно, ирвэсэнд бариулж хүний амь нас хохирсон тохиолдолд авах арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Замира хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, хэлэлцүүлгийн явцад төслийн зохицуулалтыг холбогдох бусад хуультай нийцүүлэх, хүний амь насанд хохирол учруулахаас сэргийлж чоно болон бусад зэрлэг амьтныг устгах гэсэн өөрчлөлтийг нэмэх санал хэлсэн болно.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 86,7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдганаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

ТУС3761 9023051350 9087184